

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2026/002/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ...	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
5.2 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний ергэн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.15 № 54
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ц.ГАНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 697,648.1 мянган төгрөг үндсэн дансанд хүлээн авч зардлын зүйл ангиар зарцуулж хэмнэлтийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй 62-58 ОРО улсын дугаартай Ланд круйзер 100 маркийн автомашины засварт 17,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийг төлөвлөгөөг 6 зорилт 48 арга хэмжээг

612505328

хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 94.8 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	836,000.00	1,595,000.00
БАРАА МАТЕРИАЛ	836,000.00	1,595,000.00
Түүхий эд материал	836,000.00	1,595,000.00
Тусгай зориулалттай материал	836,000.00	1,595,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	56,218,337.26	59,969,062.76
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	56,218,337.26	59,969,062.76
Биет хөрөнгө	56,218,337.26	59,969,062.76
Авто-тээврийн хэрэгсэл	58,700,000.00	58,700,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-44,514,166.43	-45,941,264.00
Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,561,600.00	49,811,800.00
Хуримтлагдсан элэгдэл	-39,048,309.51	-16,426,969.89
Тавилга, аж ахуйн эд хогшил	21,248,600.00	23,141,100.00
Хуримтлагдсан элэгдэл	-14,729,386.80	-9,315,603.35
Програм хангамж	375,000.00	375,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-375,000.00	-375,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	57,054,337.26	61,564,062.76
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	53,495,708.91	61,564,062.76
Засгийн газрын хувь оролцоо	53,495,708.91	61,564,062.76
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,307,200.00	11,307,200.00
Өмч: - төрийн	11,307,200.00	11,307,200.00
Хуримтлагдсан үр дүн	40,291,737.65	48,360,091.50
Өмнөх үеийн үр дүн	40,291,737.65	40,291,737.65
Тайлант үеийн үр дүн	0.00	8,068,353.85
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,896,771.26	1,896,771.26
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	57,054,337.26	61,564,062.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	635,630,300.00	697,648,100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,630,300.00	697,648,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,000,000.00
ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,000,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	635,630,300.00	687,648,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	635,630,300.00	687,648,100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	633,010,196.08	689,377,609.64
УРСГАЛ ЗАРДАЛ	633,010,196.08	689,377,609.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,975,196.08	651,586,724.08
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,471,269.40	251,101,505.37
Цалин	91,987,311.89	118,665,718.96
Цалингийн тусгай нэмэгдлүүд	96,483,957.51	132,435,786.41
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,317,988.55	31,213,461.17
Тэтгэврийн даатгал	20,671,988.55	26,072,480.08
Эрүүл мэндийн даатгал	3,646,000.00	5,140,981.09

Хангамж, бараа материалын зардал	23,643,552.40	21,013,753.55
Бичиг хэрэг	3,458,000.00	3,066,800.00
Тээвэр, шатахуун	19,420,000.00	16,270,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,552.40	1,676,953.55
Эд хогшил, урсгал засварын зардал	33,000,000.00	75,320,570.00
Урсгал засвар	33,000,000.00	75,320,570.00
Томилолт, зочны зардал	1,114,700.00	0.00
Дотоод албан томилолт	1,114,700.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,664,338.00	204,803,016.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,000,000.00	203,350,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	900,000.00
Даатгалын үйлчилгээ	377,338.00	138,996.00
Тээврийн хэрэгслийн татвар	0.00	277,020.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	115,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,000.00	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	109,763,347.73	68,134,417.99
Бараа үйлчилгээний бусад зардал	95,972,780.00	57,087,280.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,790,567.73	11,047,137.99
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,035,000.00	37,790,885.56
Бусад урсгал шилжүүлэг	18,681,000.00	20,120,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,294,000.00	1,790,000.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	12,870,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,822,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,565,000.00	5,460,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,354,000.00	17,670,885.56
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,354,000.00	17,670,885.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>2,620,103.92</u>	<u>8,270,490.36</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	202,136.51
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	202,136.51
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-202,136.51
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>2,620,103.92</u>	<u>8,068,353.85</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>635,630,300.00</u>	<u>697,648,100.00</u>
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>635,630,300.00</u>	<u>697,648,100.00</u>
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,000,000.00
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,000,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	635,630,300.00	687,648,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	635,630,300.00	687,648,100.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>615,661,000.00</u>	<u>682,648,100.00</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	<u>615,661,000.00</u>	<u>682,648,100.00</u>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>595,626,000.00</u>	<u>644,857,214.44</u>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,443,329.60	254,660,133.72
Цалин	89,959,372.09	122,224,347.31

Цалингийн тусгай нэмэгдлүүд	96,483,957.51	132,435,786.41
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,787,300.00	31,213,461.17
Тэтгэврийн даатгал	19,141,300.00	26,072,480.08
Эрүүл мэндийн даатгал	3,646,000.00	5,140,981.09
Хангамж, бараа материалын зардал	23,643,552.40	21,013,753.55
Бичиг хэрэг	3,458,000.00	3,066,800.00
Тээвэр, шатахуун	19,420,000.00	16,270,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	765,552.40	1,676,953.55
Эд хогшил, урсгал засварын зардал	33,000,000.00	75,320,570.00
Урсгал засвар	33,000,000.00	75,320,570.00
Томилолт, зочны зардал	1,114,700.00	0.00
Дотоод албан томилолт	1,114,700.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	232,664,338.00	205,193,016.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	232,000,000.00	203,350,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	900,000.00
Даатгалын үйлчилгээ	377,338.00	138,996.00
Тээврийн хэрэгслийн татвар	0.00	277,020.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	500,000.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	85,000.00	5,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	95,972,780.00	57,456,280.00
Бараа үйлчилгээний бусад зардал	95,972,780.00	57,456,280.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,035,000.00	37,790,885.56
Бусад урсгал шилжүүлэг	18,681,000.00	20,120,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,294,000.00	1,790,000.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	12,870,000.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,822,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,565,000.00	5,460,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,354,000.00	17,670,885.56
Төвлөрүүлэх шилжүүлэг	1,354,000.00	17,670,885.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,969,300.00	15,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,969,300.00	15,000,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,969,300.00	15,000,000.00
Дотоод эх үүсвэрээр	19,969,300.00	15,000,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,969,300.00	15,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,969,300.00	-15,000,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	37,671,633.73	50,875,604.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	37,671,633.73	50,875,604.99

Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,620,103.92	2,620,103.92
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	40,291,737.65	53,495,708.91
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	40,291,737.65	53,495,708.91
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	40,291,737.65	53,495,708.91
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	8,068,353.85	8,068,353.85
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,307,200.00	1,896,771.26	48,360,091.50	61,564,062.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	729,996,700.00	669,977,214.44	60,019,485.56	91.8
УРСГАЛ ЗАРДАЛ	729,996,700.00	669,977,214.44	60,019,485.56	91.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	705,961,700.00	649,857,214.44	56,104,485.56	92.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,920,500.00	254,660,133.72	24,260,366.28	91.3
Цалин	127,963,300.00	122,224,347.31	5,738,952.69	95.5
Цалингийн тусгай нэмэгдлүүд	150,957,200.00	132,435,786.41	18,521,413.59	87.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,365,300.00	31,213,461.17	4,151,838.83	88.3
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	29,786,900.00	26,072,480.08	3,714,419.92	87.5
Эрүүл мэндийн даатгал	5,578,400.00	5,140,981.09	437,418.91	92.2
Хангамж, бараа материалын зардал	25,360,000.00	21,013,753.55	4,346,246.45	82.9
Бичиг хэрэг	3,696,000.00	3,066,800.00	629,200.00	83.0
Тээвэр, шатахуун	19,920,000.00	16,270,000.00	3,650,000.00	81.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,744,000.00	1,676,953.55	67,046.45	96.2
Эд хогшил, урсгал засварын зардал	91,891,000.00	90,320,570.00	1,570,430.00	98.3
Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00	0.00	100.0
Урсгал засвар	76,891,000.00	75,320,570.00	1,570,430.00	98.0
Томилолт, зочны зардал	3,000,000.00	0.00	3,000,000.00	0.0
Дотоод албан томилолт	3,000,000.00	0.00	3,000,000.00	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	217,316,000.00	205,193,016.00	12,122,984.00	94.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	212,789,000.00	203,350,000.00	9,439,000.00	95.6
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	900,000.00	2,600,000.00	25.7
Даатгалын үйлчилгээ	200,000.00	138,996.00	61,004.00	69.5
Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	277,020.00	22,980.00	92.3
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00	0.00	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,000.00	5,000.00	0.00	0.0
Бараа үйлчилгээний бусад зардал	54,108,900.00	47,456,280.00	6,652,620.00	87.7
Бараа үйлчилгээний бусад зардал	54,108,900.00	47,456,280.00	6,652,620.00	87.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,035,000.00	20,120,000.00	3,915,000.00	83.7
Бусад урсгал шилжүүлэг	24,035,000.00	20,120,000.00	3,915,000.00	83.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,200,000.00	1,790,000.00	2,410,000.00	42.6

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,870,000.00	12,870,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,965,000.00	5,460,000.00	1,505,000.00	78.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	729,996,700.00	669,977,214.44	60,019,485.56	91.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	729,996,700.00	669,977,214.44	60,019,485.56	91.8
Орон нутгийн төсвөөс	729,996,700.00	669,977,214.44	60,019,485.56	91.8
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	7.50	7.50	0.00	100.0
Удирдах ажилтан	2.00	2.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	2.50	2.50	0.00	100.0
Гэрээт ажилтан	3.00	3.00	0.00	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7.50	7.50	0.00	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	2.00	2.00	0.00	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1.50	1.50	0.00	100.0
Гэрээт ажилтан	3.00	3.00	0.00	100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
ЗГНХ,ЗДНХөрсөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа сонгуулийн эрх бүхий иргэдээс сонгогддог, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, бүрэн эрхийг хамтын удирдлагын зарчмын үндсэн дээр хэрэгжүүлдэг нутгийн өөрөө удирдах байгууллага юм.

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхийн асуудал, Хурлын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, тухайн Хурлын хороог байгуулах, хорооны бүрэлдэхүүн, даргыг сонгох, өөрчлөх, тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, огцруулах талаар дээд шатны Засаг даргад санал тавих,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх,
- тухайн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийн талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт, дүгнэлт өгөх,
- нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах,
- Засаг даргын өргөн мэдүүлснээр тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гүйцэтгэлийг батлах,
- хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох, орон нутгийн өмчийн зүйлсийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, дүрмийг батлах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх,
- хуулиар тусгайлан эрх олгогдсон тохиолдолд захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэн мөрдүүлэх,
- худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах,
- хуульд заасан бусад бүрэн эрх.

Алсын хараа: Иргэдийн оролцоонд суурилсан сайн засаглалтай нутгийн өөрөө удирдах байгууллага болно.

Эрхэм зорилго нь: Оновчтой бодлогоор-Тогтвортой хөгжлийг хангана.

Байгууллагын стратегийн зорилт нь: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дор дурдсан стратегийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, үндсэн чиглэлийг тодорхойлоход нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хурлын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг боловсронгуй болгох,

- Сумын ИТХ-ын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгож, түүний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх,

- Сумын ИТХ-ын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, эргэх холбоог бий болгох,

- Сумын ИТХ-ын Ажлын албыг бэхжүүлэх, үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанарыг сайжруулах,

- ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх.

Дээрх зорилтуудын хүрээнд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.8 оноотой дүгнүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

- Монгол Улсын үндсэн хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухайн хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70.5-д "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно." гэж нэмсэн.
- Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/03 дугаар захирамжаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам".

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан байхгүй байна. Дотоод аудитын чиг үүргийг ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Үйл ажиллагаандаа Орхон аймгийн Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар баталсан "Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг ашиглаж байгаа бөгөөд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох

хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн тайлангаа Сангийн сайдын тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,509.7 мянган төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	836.0	1,595.0	759.0
Үндсэн хөрөнгө	56,218.3	59,969.1	3,750.8
Нийт хөрөнгө	57,054.3	61,564.1	4,509.8
Өр төлбөр	3,558.6	0.0	-3,558.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	53,495.7	61,564.1	8,068.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	57,054.3	61,564.1	4,509.8

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын данс тусгай зориулалтын материалын өсөлтөөр нэмэгджээ.

Үндсэн хөрөнгийн данснаас 37,655.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 37,857.3 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө хасагдаж, тайлант онд 15,000.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 11,047.1 мянган төгрөгийн элэгдэл тооцсонтой холбоотойгоор нийт 3,750.8 мянган төгрөгөөр дансны үнэ нэмэгджээ.

Өмнөх оны НДШ-ийн 3,558.6 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан тул өглөг буурсан, Засгийн газрын оролцоо данс нь тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 601,786.6 мянган төгрөгөөр бүрдүүлж, нийт зарлагыг 601,786.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 88,210.4 мянган төгрөгөөр өсгөж 689,996.7 мянган төгрөгөөр баталсан¹.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

¹ Жаргалант сумын ИТХ-н 2024.12.31-ны өдрийн 02/31 дугаар тогтоол. Жаргалант сумын 2025 оны төсөв батлах тухай

Тайлант оны батлагдсан төсвийг 40,822.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгон баталсан² байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70105 /Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага/ хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 635,630.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 634,276.3 мянган төгрөгийг зарцуулж 1,354.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 634,276.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь орон тооны хэмнэлтээс үүдэн цалин, НДШ-ын зардлыг 1,691.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 454.8 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 416.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3,816.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 14.0 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	729,996.7	669,977.2	60,019.5	91.8%
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	667,543.8	617,080.9	50,462.9	92.4%
1.2	Мэдээлэл, сурталчилгааны зардал	10,000.0	10,000.0	0.0	100.0%
1.3	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2,789.0	0.0	2,789.0	0.0%
1.4	Ажил олгогчоос олгох тэтгэмж	11,165.0	7,250.0	3,915.0	64.9%
1.5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаа	12,870.0	12,870.0	0.0	100.0%
1.6	Ангилалдаагүй бусад зориулалт	25,628.9	22,776.3	2,852.6	88.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн гэмт хэргээс урьдчилсан ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 10,000.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, зарцуулсан байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан нэмэлтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй болно.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, батлагдсан төсвийн хүрээнд урсгал зардлуудын худалдан авалтыг шууд гэрээ байгуулан болон нэхэмжлэхээр худалдан авсан байна.

² Жаргалант сумын ИТХ-н 2025.07.28-ны өдрийн 02/10 дугаар тогтоол. Жаргалант сумын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зардлын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвхагва нар тус тус хэрэгжүүллээ.

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн дүнгүүд нь харилцан адилгүй буюу хөрөнгийн дүн харьцангуй бага, нийт орлого нь тухайн онд хүлээн авсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос хамаарч хэлбэлздэг бөгөөд төсвийн байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийдэг тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн 729,996.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,949.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төрийн хэмнэлтийн хуулийн үйлчлэлийн хүрээнд ажиллаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 171 талбарын мэдээллээс хугацаандаа 165 талбарын мэдээлэл, хугацаа хоцроож 6 талбарын мэдээлэл оруулсан байна. Үүнд: 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 10-р сар, 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 10-р сар, 3. Санхүүгийн тайлан - Хагас жил, 4. Дараа жилийн төсвийн төсөл, 5. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 6. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт - 10-р сар

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулсан мэдээллийг хянаж баримтжуулсан.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, нэгдсэн цахим хуудасны хөтлөлттэй холбоотой зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн 3,206.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 4,020.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын системд хянаж баталгаажуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,206.1	2	3,206.1	100.0%
Зөвлөмж	3	4,020.1	3	4,020.1	100.0%
Нийт дүн	5	7,226.2	5	7,226.2	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал дансыг авч үзэж болох юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,029.3 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 2,160.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 3,869.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгч байна.

5.1 Төлбөрийн акт

Хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын дутуу төвлөрүүлсэн болон анхан шатны баримтгүй зарцуулсан зардлын нийт 2,160.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 1,769.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны үндсэн данснаас шилжүүлж байгууллагын данс хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн болон нэмэлт дансны хооронд гүйлгээ хийгүй байх.

2. Нэмэлт данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд аймгийн ИТХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлсэн "Хөршийн холбоо" малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан төсвөөс сумын төвийн 2 багийн 21 иргэнд 2,100.0 мянган төгрөгийн шатахууны зардал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төлөвлөсөн арга хэмжээнд, үр ашигтай зарцуулах.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт - 10-р сар, 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал - 10-р сар, 3. Санхүүгийн тайлан - Хагас жил, 4. Дараа жилийн төсвийн төсөл, 5. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, 6. Байгууллагын

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт - 10-р сарийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаа хоцроохгүй мэдээлж, мэдээллийг ил тод байдлыг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 02 дугаар 16 сарын

Дугаар 95/А1460336

Баян-Өндөр сум

ОРА-2026/002/МА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн сургалтын зардлын сургагч багшийн 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхан шатны баримтгүй зарцуулсан 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

612511315

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Ганбаяр), нягтлан бодогч (Н.Мядагмаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ
АУДИТОР:  Г.ОРГИЛМӨРӨН

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ТӨЛБӨРИЙН АКТ

2026 оны 02 дугаар 16 сарын

Дугаар 96/А.1460336
ОРА-2026/002/НА-СТА-ТШЗ

Баян-Өндөр сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүний 1,600.0 мянган төгрөгийн орлогоос 160,000 (Нэг зуун жаран мянга) төгрөгийн татварыг суутгаж төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Татварын ерөнхий хуулийн 29.1-д "Татвар төлөгч татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу цахим, эсхүл цаасан хэлбэрээр үйлдэж, харьяа татварын албанд тушаана. Татвар төлөгч дараах үүргийг хүлээнэ", 29.1.3-д "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын суутган тооцож төлөх татварыг дутуу төвлөрүүлсэн 160,000 (Нэг зуун жаран мянга) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

612511318

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Ганбаяр), нягтлан бодогч (Н.Мядагмаа) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН
МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АХЛАХ
АУДИТОР:  Г.ОРГИЛМӨРӨН

¹ Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-9826

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

	Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/														
		Нийт зөрчил		Төлбөрийн акт				Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
																Тоо
	Хувь хүнд олгосон орлогоос татвар суутгаагүй болон суутгасан татварыг шилжүүлээгүйгээс суутган төлөх албан татварыг нийт 160.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	1	160.0	1	160.0											
	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны А/24 дүгээр захирамжаар баталсан сумын Төлөөлөгчдийн сургалтын зардлын сургагч багшийн 2,000.0 мянган төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний үнэд нэмж шилжүүлсэн байна.	1	2,000.0	1	2,000.0											
	Нэмэлт санхүүжилтийн данснаас шилжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 1,769.3 мянган төгрөгийг үйл ажиллагааны үндсэн данснаас шилжүүлж байгууллагын хооронд гүйлгэн зарцуулсан байна.	1	1,769.3							1	1,769.3					
	Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 6 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0.0							1	0.0					
	Тайлант онд аймгийн ИТХ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлсэн "Хөршийн холбоо" малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагаанд нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан төсвөөс сумын төвийн 2 багийн 21 иргэнд 2,100.0 мянган төгрөгийн шатахууны зардал олгосон байна.	1	2,100.0							1	2,100.0					
Дүн		5	6,029.3	2	2,160.0					3	3,869.3					